



ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 07

Чингис хот

Салбар комисс шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.2.1, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.5, 3.5.3, 2019 оны 15 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-ын 3.1, 3.3, 3.4, 6.1, 11.1-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2 танхимд зохион байгуулах болсон тул холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах, шалгалттай холбоотой иргэдээс гарсан санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх салбар комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр, дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, туслах ажлын хэсгийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулахад дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг арга зүйгээр хангаж, холбогдох хууль, журмын хүрээнд шударга, ил тод, иргэдийг адил тэгш боломжоор хангах зарчмыг баримталж, алдаа, маргаангүй зохион байгуулахад анхаарч ажиллахыг салбар комиссын дарга, дэд ажлын хэсгийн ахлагч нарт даалгасугай.

3. Төрийн албаны ерөнхий шалгалтын тайлан, холбогдох материалыг хугацаанд нь Төв комисст хүргүүлэхийг нарийн бичгийн дарга /Ж.Саруултөгс/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР


Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн
2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн
07-дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



ТӨРИЙН АЛБАНЫ ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ САЛБАР КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Салбар комиссын дарга:	Ж.Гантулга	Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ж.Саруултөгс	Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Г.Лхагвахатан	Салбар зөвлөлийн гишүүн, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Б.Баярсайхан	Салбар зөвлөлийн гишүүн, Шүүхийн тамгын газрын дарга
	Г.Болд	Салбар зөвлөлийн гишүүн, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн
2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн
.07...дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1 дүгээр ажлын хэсгийн
ахлагч:

Ж.Гантулга Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Г.Лхагвахатан Салбар зөвлөлийн гишүүн, Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга

Ц.Ганчимэг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
хэлтсийн Нутгийн захиргааны байгууллагын хяналт-
шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан
мэргэжилтэн

Л.Наранбат Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад
харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан
мэргэжилтэн

П.Ариунбаатар Боловсрол, соёл, урлагийн газрын Статистик, хяналт-
шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн

2 дугаар ажлын хэсгийн
ахлагч:

Ж.Саруултөгс Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн
удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:


Б.Баярсайхан Салбар зөвлөлийн гишүүн, Шүүхийн тамгын
газрын дарга

Г.Болд Салбар зөвлөлийн гишүүн, Хэрлэн сумын Засаг
даргын Тамгын газрын дарга

Ж.Энхбат Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
Компьютерийн технологи, програм хангамж хариуцсан
мэргэжилтэн

Д.Тогоонпүрэв Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн
2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн
07 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт



ТУСЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

1. Цагдаагийн газар – 2
2. Онцгой байдлын газар – 1
3. Нэгдсэн эмнэлэг – 4
4. Цахилгаан түгээх сүлжээ салбар – 1
5. Лаборатори 1 дүгээр сургууль – 6